



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 1/117

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.4, 67.5 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.4 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Гадаад харилцааны асуудал хариуцсан мэргэжилтэн жирэмсний болон амаржсаны амралттай, Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн хүүхэд асрах чөлөөтэй байгаа тул тус төрийн жинхэнэ албан хаагчдын үүргийг түр орлон гүйцэтгэгчдийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Ганболд (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга)

Гишүүд: Н.Ганзориг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

Нарийн бичиг: Б.Гантөмөр (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

2. Ажлын хэсгийн гишүүдийг арга зүйгээр хангаж, сонгон шалгаруулалтыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, дүнг ажлын 3 хоногт багтаан танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Ганболд)-д даалгасугай.

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.БАЯРСҮХ

